

НИЙСЛЭЛИЙН ЦАГДААГИЙН УДИРДАХ ГАЗАР

**ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ УХУУЛГА,
СУРТАЛЧИЛГААНЫ АЖИЛД ҮНИЙН САНАЛ
АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр:

**“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ухуулга,
сурталчилгааны ажил”
НИТХ/202005003**

**УЛААНБААТАР ХОТ
2020 ОН**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Нийслэлийн цагдаагийн удирдах газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгааны ажил** – д үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Багц-1:Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгааны богино хэмжээний видео шторк хийх

Багц-2:Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгааны 3D зохиомжит зураг зуруулах, хэвлэмэл хуудасны эх бэлтгэл, хэвлэл

Багц-3:Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгаа, мэдээллийг лифтний самбар байршуулах

Багц-4:Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчилах подкаст, видео нэвтрүүлэг хийх

Багц-5:Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчилах хулдаасан самбар байршуулах

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 10:00 цаг-аас өмнө [Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. **Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлнэ.**] хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн [10:40 цаг]**¹-т нээнэ.

“Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй”

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Бага тойруу,
Ж.Самбуугийн гудамж-18, өөрийн байр, Утас: 70191210
Нийслэлийн цагдаагийн удирдах газар,**

¹ Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ.Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн [1] жилийн санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/; 2. Сүүлийн [1 жилийн тоо] туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/; 3. <i>Тендерийн маягтын дагуу үнийн санал бусад мэдээллээ баталгаажуулан /гарын үсэг, тамга/ ирүүлнэ.</i> 4. <i>Компанийн дэлгэрэнгүй танилцуулга ирүүлнэ.</i> 5. <i>Байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээг ирүүлэх шаардлагагүй бөгөөд www.tender.gov.mn цахим системээс хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийг шалгана.</i> 6. <i>Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэл ирүүлнэ.</i> 7. <i>Цахим татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд www.tender.gov.mn мэдээллийн системээс тендерт оролцогчийн татварын дутуу үлдэгдэлийн талаарх мэдээллийг шалгана. /Тендерт оролцогч нь тендер нээсэн өдрийн байдлаар татварын дутуу үлдэгдэлгүй байх ёстой./</i> 8. <i>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт ирүүлнэ.</i> 9. <i>Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт ирүүлнэ.</i> 10. <i>Захиалагчаас тогтоосон техникийн тодорхойлолтын дагуу техникийн тодорхойлолт ирүүлнэ.</i> 11. <i>Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэг онд борлуулалтын орлого нь захиалагчийн батлагдсан нийт төсөвт өртгийн 100 хувиас багагүй байна.</i> 12. <i>Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг дор хаяж нэг удаагийн гэрээгээр гүйцэтгэсэн байх ба гэрээ болон гэрээ дүгнэсэн актын хуулбар, захиалагчийн тодрхойлолтыг ирүүлнэ.</i> <p><i>ТШӨХ-д заасан материалуудаас аль нэгийг ирүүлээгүй, шаардлага хангаагүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Бага тойруу, Ж.Самбуугийн гудамж-18, өөрийн байр, Утас: 70191210, Нийслэлийн цагдаагийн удирдах газар,</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. <i>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлнэ.</i></p> <p>Огноо: 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдөр</p>

	Цаг: 10 цаг 00 минут
ТӨЭЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Бага тойруу, Ж.Самбуугийн гудамж-18, өөрийн байр, Утас: 70191210, Нийслэлийн цагдаагийн удирдах газар,</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Огноо: 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 40 минут</p>
ТӨЭЗ 2.3	Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:
ТӨЭЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p>Багц-1:Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгааны богино хэмжээний видео шторк хийх</p> <p>Багц-2:Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгааны 3D зохиомжит зураг зуруулах, хэвлэмэл хуудасны эх бэлтгэл, хэвлэл</p> <p>Багц-3:Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгаа, мэдээллийг цахилгаан шатны самбар байршуулах</p> <p>Багц-4:Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчилах подкаст, видео нэвтрүүлэг хийх</p> <p>Багц-5: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчилах хулдаасан самбар байршуулах</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Багц-1:

Барааны тодорхойлолт: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгааны богино хэмжээний видео шторк хийх

1. **Стандарт:** Сурталчилгааны бичлэгийг мэргэжлийн программ хангамж дээр суурилан гүйцэтгэх
2. **Гүйцэтгэл:** Зураг авалтын зохиол, дүрслэлийг боловсруулж, мэргэжлийн зураг авалт, дуу дүрсний өндөр үзүүлэлттэй, оршин үеийн технологийн дэвшил, програм хангамжийг ашиглан мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр дүрслэн гүйцэтгэж, тус бүрийг өндөр нягтаршилтай, 4K форматаар DVD дээр хуулбарлан өгөх / нэг бичлэгийн үргэлжлэх хугацаа 2-3 минут байна/
3. **Барааны зориулалт:** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд байгууллагын цахим хуудас /www.ub.police.gov.mn/, олон нийтийн сүлжээ хуудас /facebook, twitter/, телевизүүдээр дамжуулан иргэд, олон нийтэд хүргэх

Багц-2:

Барааны тодорхойлолт: Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгааны 3D зохиомжит зураг зуруулах, хэвлэмэл хуудасны эх бэлтгэл, хэвлэл

1. **Стандарт:** Батлагдсан эх бэлтгэл, техникийн тодорхойлолтод заасан цаас, хэмжээ, тоо ширхгийн дагуу чанарын өндөр түвшинд хийх
2. **Гүйцэтгэл:** Батлагдсан эх бэлтгэлийн дагуу 4 төрлийн 3D комикс зураг, А4-А5 хэмжээгээр заагдсан тоо ширхэг хэмжээгээр зориулалтын фото стикер цаасан дээр нар салхинд гандахгүй будагтай, ус нэвтрэхгүй бүрэлттэй, орчин үеийн өнгөний дүрслэлээр хэвлэх /А4-6000ширхэг, А5-6000ширхэг/
3. **Барааны зориулалт:** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд нээлттэй хаалганы өдөрлөг, уулзалт, зөвлөгөөн, сургалтын үеэр болон иргэд олноор цуглардаг газруудад байршуулан иргэд, олон нийтэд хүргэх,

Багц-3:

Барааны тодорхойлолт: Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгаа, мэдээллийг цахилгаан шатны самбарт байршуулах

1. **Стандарт:** Батлагдсан эх бэлтгэл, техникийн тодорхойлолтод заасан цаас, хэмжээ, тоо ширхгийн дагуу чанарын өндөр түвшинд хийх
2. **Гүйцэтгэл:** А3 хэмжээгээр заагдсан тоо ширхэг хэмжээгээр зориулалтын фото стикер цаасан дээр нар салхинд гандахгүй будагтай, ус нэвтрэхгүй бүрэлттэй, орчин үеийн өнгөний дүрслэлээр хэвлэх, хотын төвийн орон сууцны цахилгаан шатны сурталчилгааны самбарт 14 хоног байршуулах түрээс багтана.
3. **Барааны зориулалт:** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээний талаар иргэд олон газруудад байршуулан иргэд, олон нийтэд хүргэх,

Багц-4:

Барааны тодорхойлолт: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчилах подкаст видео нэвтрүүлэг хийх

1. **Стандарт:** Сурталчилгааны бичлэгийг мэргэжлийн программ хангамж дээр суурилан гүйцэтгэх

2. **Гүйцэтгэл:** Мэргэжлийн зураг авалт, дуу дүрсний өндөр үзүүлэлттэй, оршин үеийн технологийн дэвшил, програм хангамжийг ашиглан мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр дүрслэн гүйцэтгэж, тус бүрийг өндөр нягтаршилтай, 4K форматаар DVD дээр хуулбарлан өгөх, /нэг бичлэгийн үргэлжлэх хугацаа 10-15 минут/
3. **Барааны зориулалт:** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд байгууллагын цахим хуудас /www.ub.police.gov.mn/, олон нийтийн сүлжээ хуудас /facebook, twitter/, телевизүүдээр дамжуулан иргэд, олон нийтэд хүргэх

Багц-5:

Барааны тодорхойлолт: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчилах хулдаасан самбар байршуулах

1. **Стандарт:** Батлагдсан эх бэлтгэл, техникийн тодорхойлолтод заасан хэмжээ, тоо ширхэгийн дагуу чанарын өндөр түвшинд хийх
2. **Гүйцэтгэл:** Хот А бүст төв зам дагуу байрлах сурталчилгааны нэг тал нь 9*4м/кв хэмжээтэй мэдээллийн байгууламж бүхий нийт 288м² хэмжээтэй 4 төрлийн 8 тал самбар Бельги хулдаасан материал дээр нар салхинд гандахгүй будагтай, ус нэвтрэхгүй бүрэлттэй, орчин үеийн өнгөний дүрслэлээр хэвлэх, тогтоох, буулгах, байршуулах, 14 хонгийн түрээс багтана.
3. **Барааны зориулалт:** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчилах хулдаасан самбар байршуулан иргэд, олон нийтэд хүргэх,

Бараа хүргэх газар: Нийслэлийн цагдаагийн удирдах газар

Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Багц-1	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгааны богино хэмжээний видео шторк хийх	4	Ширхэг	НЦУГ Төв байр	2020.06.29	2020.06.30	
Багц-2	Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгааны 3D зохиомжит зураг зуруулах, хэвлэмэл хуудасны эх бэлтгэл, хэвлэл /4 төрлийн 3D зохиомжит зураг А4, А5 хэмжээтэй /	А4-6000 А5-6000	Ширхэг	НЦУГ Төв байр	2020.06.29	2020.06.30	

Багц-3	Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ухуулга, сурталчилгаа, мэдээллийг цахилгаан шатны самбар байршуулах /АЗ хэмжээтэй хэвлэл, 14 хоног байршуулах түрээс багтана/	300	Ширхэг	НЦУГ Төв байр	2020.06.29	2020.06.30	
Багц-4	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчилах подкаст, видео нэвтрүүлэг хийх /нэг бичлэгийн үргэлжлэх хугацаа 10-15 минут/	12	Ширхэг	НЦУГ Төв байр	2020.06.29	2020.06.30	
Багц-5	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчилах хулдаасан самбар байршуулах /4 төрлийн 1 тал нь 361м/кв хэмжээтэй 8 тал самбар, 14 хонгийн түрээс, буулгалт, тогтоолт багтана/	288	м/кв	НЦУГ Төв байр	2020.06.29	2020.06.30	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД БӨГӨӨД
НИЙСЛЭЛИЙН ЦАГДААГИЙН УДИРДАХ ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Д.ЯДАМДОРЖ ТАНАА**

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|----------------------------------------------------|-------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн 100² хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)³ 9.1. Алданги оногдуулах хувь: **[0,5]**
- Алдангийн нийт дүн: **[10%]**

² Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

³ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ⁴

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁵;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

⁴ Гэрээбайгуулахүедүүнийгхасна.

⁵ Хоёрталхарилцантохиролцожгэрээнийнөхцөлдоруулсанзайлшгүйшаардлагатайнэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]